

**“ТЭЭВЭР АЧЛАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

Огноо: 2025/02/10

Дугаар:01/26

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурал зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5 дах хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дах хэсэг, 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, “Тээвэр ачлал” ХК (“Компани” гэх)-н Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн хурлын эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ийг 2025 оны 03 дугаар сарын 28-ний өдрийн 12:00 цагт компанийн өөрийн байранд хуралдуулсугай.
2. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 03 сарын 04-ний өдрөөр тогтоосугай.
3. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн бирж-д 2025 оны 02 сарын 11-ны өдрийн дотор шаардлагатай баримт бичгийн хамт тус тус хүргүүлсүгэй.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын сонинд 2025 оны 02 сарын 13-ны өдрийн дотор нийтэд мэдээлсүгэй.
5. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хурал зохион байгуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахад шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах коммист даалгасугай.
6. Хурлаар хэлцэх асуудал:
  1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
  2. Компанийн 2025 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах
  3. Компанийн хэлбэр өөрчлөх.

ТУЗ-ИЙН ДАРГА



/Б. БАТЗОРИГ/